



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/462

Улаанбаатар хот

Гамшгаас урьдчилан сэргийлэх,
эрсдэлийг бууруулах ажлын дундаж үзүүлэлтийг дүгнэх
аргачлал, заавар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4, 30 дугаар зүйлийн 30.1.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлын дундаж үзүүлэлтийг дүгнэх аргачлал, заавар”-ыг нэгдүгээр, “Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлын дундаж үзүүлэлт”-ийг хоёрдугаар, “Урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах хийсэн ажилд өгөх үнэлгээ”-г гуравдугаар, “Гамшгаас хамгаалах ангиллын сургалт зохион байгуулсан байдалд өгөх үнэлгээ”-г дөрөвдүгээр, “Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан тухай баталгааны хуудас”-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ зааврыг 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, Гамшгаас хамгаалах сургалтын төв 116 дугаар ангийн захирагч нарт үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож, үнэлэлт, дүгнэлт өгч ажиллахыг Гамшгаас хамгаалах сургалтын газар (хурандаа Х.Сүхбаатар), Эрсдэлийн удирдлагын газар (хурандаа Д.Баасансүрэн)-т тус тус даалгасугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны А/133 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

1425013288

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн
А/412 дугаар тушаалын 01 дүгээр хавсралт

ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АЖЛЫН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ДҮГНЭХ АРГАЧЛАЛ, ЗААВАР

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшгаас хамгаалах сургалтын төв 116 дугаар анги, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, гамшгаас хамгаалах сургалт, олон нийттэй харилцах ажлыг төлөвлөх, зохион байгуулах, ажлын дундаж үзүүлэлтийг тогтоох, үнэлж дүгнэхэд энэхүү аргачлал, зааврыг баримтална.

1.2. Зааврыг хэрэгжүүлэхэд Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлагдсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2018 оны А/181 дүгээр тушаалаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хэрэгжүүлэх “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөр бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг удирдлага болгоно.

ХОЁР. ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

2.1. Ажлын гүйцэтгэлийг төлөвлөх

2.1.1. “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Онцгой байдлын ерөнхий газрын үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр туссан арга хэмжээг Гамшгаас хамгаалах сургалтын төв 116 дугаар анги, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх.

2.1.2. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлын дундаж үзүүлэлтийг бүрэн ханган биелүүлэх ажлыг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс, тасаг хариуцах бөгөөд энэ ажилд Онцгой байдлын газрын бусад алба хаагчийг татан оролцуулж, өргөн хүрээтэй зохион байгуулах.

2.1.3. Аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээний хэтийн төлөвлөлтийн санал боловсруулж, тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт тусгуулах.

2.1.4. Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийн асуудлыг төлөвлөж, улсын төсөвт тусгуулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах.

2.1.5.Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын чанар, үр дүнд шинжилгээ хийх, санал дүгнэлт боловсруулан орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, Онцгой байдлын ерөнхий газрын гамшгаас хамгаалах сургалт хариуцсан зохион байгуулалтын нэгжид хувийг ирүүлж байх.

2.1.6.Гамшгаас хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө, санамж бичиг байгуулж, хэрэгжилтийг хангах.

2.2.Нэгдсэн арга хэмжээ, өдөрлөг, анхааруулах, сэрэмжлүүлэх

2.2.1.Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой комиссын даргын баталсан удирдамжтай Гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийг заагдсан хугацаанд нь чанартай зохион байгуулах.

2.2.2.Онцгой байдлын ерөнхий газар бусад яам, агентлагийн хамтран баталсан удирдамж, зааврын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах.

2.2.3.Бүс нутаг, байгаль цаг уур, үйлдвэр, дэд бүтэц, хүн амын нягтрал зэрэг онцлогтой уялдуулан гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, өдөрлөгийн удирдамж боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргаар батлуулан хэрэгжүүлэх.

2.2.4.Объектын болон ой, хээрийн гал түймэр, үер зэрэг аюулт үзэгдэл, ахуй болон үйлдвэрлэл, технологи, усны ослоос урьдчилан сэргийлэх, анхааруулах, сэрэмжлүүлэх самбарыг эрсдэл бүхий газруудад байршуулах.

2.2.5.Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нийслэл, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын харьяа салбар, нэгжүүд болон зах худалдааны төв, олон нийтийн үзвэр үйлчилгээний газрууд болон хүн олноор цуглардаг цэгүүдэд аюулт үзэгдэл, ослоос сэрэмжлүүлэх, мэдээлэл, сурталчилгааны самбар байршуулж иргэд, олон нийтийг сэрэмжлүүлэг мэдээллээр хангах.

2.2.6.Гамшгийн эрсдэлийг үнэлэх, бууруулах үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, байгууллага, иргэд олон нийтийн оролцоог хангах.

2.3.Сурталчилгаа, олон нийттэй харилцах

2.3.1.Орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг, гэрээ байгуулан телевиз, FM радиод мэдээлэл, нэвтрүүлгийн тогтмол цагтай болох, сонин хэвлэлд тусгай булантай болох.

2.3.2.Иргэд, олон нийтийн гамшгаас хамгаалах мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор ТВ хичээл болон цаг үеийн мэдээлэл, болзошгүй аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан түгээх.

2.3.3.Монгол оронд зонхилон тохиолддог аюулт үзэгдэл, ослын төрөл бүрээр видео хичээл, сэрэмжлүүлэг шторкийн эх бэлтгэх, сургалт, сурталчилгааны материалын мэдээллийн сан бүрдүүлэх.

2.3.4.Онцгой байдлын газар түүний харьяа нэгжээс зохион байгуулсан гамшгаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ, өдөрлөг, ангиллын сургалт, эрэн хайх, аврах, гал түймэр унтраах ажиллагаа, хүмүүнлэгийн тусламж, алба сурталчлах зэрэг аливаа үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээлэл, нийтлэлийг Онцгой байдлын ерөнхий газрын албан ёсны цахим хуудас болон орон нутгийн цахим хуудсанд тухай бүр байршуулж, олон нийтэд түгээх.

2.3.5.Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг шторк, сурталчилгааны материалын эхийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон belenbai.mn цахим хуудсаас орон нутгийн цахим хуудсанд татан байршуулж, олон нийтэд хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх.

2.4.Гамшгаас хамгаалах сургалт

2.4.1.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/181 дүгээр тушаалаар батлагдсан "Аюулгүй амьдрах ухаан" сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр орон нутаг дахь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлагатай хамтран ажиллах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх.

2.4.2.Монгол Улсын Шадар сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2019 оны 114/А/765 дугаар тушаал "Аюулгүй амьдрах ухаан" сургалтын хөтөлбөрийг эрчимжүүлэх ажлыг орон нутгийн Засаг дарга, Боловсрол, соёл урлагийн газрын удирдлагатай хамтран хэрэгжүүлэх.

2.4.3.Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны А/103 дугаар тушаал "Гамшгаас хамгаалах менежментийн үндэс" хичээлийг оюутнуудад судлуулах чиглэлээр их, дээд сургуулийн удирдлагатай хамтран ажиллах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, сургалтын чанар үр дүнд хяналт тавих, бүртгэл судалгаа хөтлөх.

2.4.4.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/138 дугаар тушаал "Гамшгаас хамгаалах мэдлэг олгох хичээл"-ийг суралцагсдад судлуулах чиглэлээр Политехникийн коллеж, Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн удирдлагатай хамтран ажиллах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх, сургалтын чанар, үр дүнд хяналт тавих, бүртгэл судалгаа хөтлөх.

2.4.5.Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/130 дугаар тушаалаар баталсан "Ангиллын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө"-ний дагуу удирдах албан тушаалтан, мэргэжлийн анги, ажилтан албан хаагч, иргэд, сайн дурынхны сургалтыг зохион байгуулах.

2.4.6.Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, асран хамгаалагч нарт жилд хоёроос доошгүй удаа гамшгаас хамгаалах сургалтыг заавал зохион байгуулж орсон байх.

2.4.7.Онцгой байдлын ерөнхий газар, Насан туршийн боловсролын үндэсний төв хооронд байгуулсан "Хамтран ажиллах санамж бичиг"-ийн хэрэгжилтийг хангах хүрээнд орон нутаг дахь Насан туршийн боловсролын төвийн багш нарыг гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр сургагч багшаар бэлтгэх, тэднээр дамжуулан иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалт явуулах аргаар, гамшгаас хамгаалах ангиллын сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх.

2.4.8.Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан ангиллын сургалтыг иргэд, олон нийтэд хүртээмжтэй хэлбэрээр хүргэх зорилгоор дэвшилтэт технологи ашиглан цахим болон видео хичээл бэлтгэн явуулах.

2.4.9.Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/412 дугаар тушаалаар баталсан "Гамшгаас хамгаалах иж бүрэн болон команд штабын сургууль, дадлага зохион байгуулах" зааврын хэрэгжилтийг орон нутагт хангах.

2.4.10.Иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг, дадлага олгох сургалт, арга зүйн төвтэй болох ажлыг улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаад, дотоодын төсөл хөтөлбөртэй хамтран үе шаттай хэрэгжүүлэх.

ГУРАВ. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АЖЛЫН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ДҮГНЭХ АРГАЧЛАЛ

3.1. Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлын дундаж үзүүлэлтийг хүснэгт 1-ийн дагуу шалгаж үнэлгээ өгнө. Жишээ нь:

Урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ 3 удаа зохион байгуулахаас 2 удаа хийсэн бол $66,6$ хувь, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажлын талаар телевизэд ярилцлага 6 удаа өгөхөөс 5 удаа өгсөн бол $83,3$ хувь, урьдчилан сэргийлэх чиглэлээр шторк, сэрэмжлүүлгийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 80 удаа явуулахаас 75 удаа явуулсан бол $93,75$ хувь, иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа 36 удаа зохион байгуулахаас 36 удаа явуулсан бол 100 хувь, байгууллагын цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл 180 удаа байршуулахаас 170 удаа байршуулсан бол $94,4$ хувь гэж үзээд авсан оноог хооронд нь нэмж 5-д хуваагаад дундаж үзүүлэлтийн хувийг гаргана. Нийлбэр $438,05/6=87,61$ дундаж үзүүлэлт $87,61$ буюу "В" гэж дүгнэнэ.

3.2. Дундаж үзүүлэлт, төлөвлөгөөний биелэлт, үр дүн, хийсэн ажлаа материалжуулсан байдал, тайлан ирүүлсэн хугацаа зэргийг хүснэгт 2-ын дагуу дүгнэнэ.

Дундаж үзүүлэлтийг үнэлэх Жишээ нь $83,71*40/100=33.5$ оноо,

Төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ тухайн улиралд хийхээр төлөвлөсөн ажлыг, гүйцэтгэлд нь харьцуулан дүгнэнэ. Жишээ нь төлөвлөгөө 75 хувийн биелэлттэй гэж үзвэл $75*20/100=15$ оноо,

Үр дүнг тооцохдоо төлөвлөсөн ажил, хамрагдагсдын хүрээ, хийсэн ажлын гүйцэтгэл зэргийг харгалзан үзэж дүгнэнэ. Жишээ нь $80*80/100=16$ оноо,

Зохион байгуулсан урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зэрэг ажлуудын материалыг бүрдүүлж, зурагжуулж, хавтасласан байна. Жишээ нь $60*10/100=6$ оноо,

Тайлангаа хугацаандаа ирүүлсэн бол 10 оноо,

Нийт жилийн эцсийн урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах дундаж үзүүлэлт $33,5+15+16+6+10=80,5$ оноо буюу "В" буюу "Хангалттай" үнэлгээ авсан гэж үзнэ.

ДӨРӨВ. ГАМШГААС ХАМГААЛАХ АНГИЛЛЫН СУРГАЛТ, ТҮҮНИЙ ҮР ДҮНГ ДҮГНЭХ АРГАЧЛАЛ

4.1. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшгаас хамгаалах сургалтын төв 116 дугаар анги, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах сургалтын ажлын дундаж үзүүлэлтийг хүснэгт 3-ын дагуу шалгаж үнэлгээ өгнө.

4.2. Дүгнэхэд хамаарах хүрээг аймаг, нийслэл, сум, дүүргийн хүн ам, газар зүйн байршил, аж ахуйн нэгж байгууллага, сургалт зохин байгуулах мэргэжилтний тоо зэргийг харьцуулан дараах 6 хэсэгт хуваана.

4.2.1. нэгдүгээр хэсэгт (Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг),

4.2.2. хоёрдугаар хэсэгт (Дархан-Уул, Орхон, Өвөрхангай, Сэлэнгэ, Ховд,

Хөвсгөл, Төв, Өмнөговь, Баян-Өлгий),

4.2.3.гуравдугаар хэсэгт (Баянхонгор, Дорнод, Увс, Булган, Дорноговь, Сүхбаатар, Хэнтий, Завхан)

4.2.4.дөрөвдүгээр хэсэгт (Дундговь, Архангай, Налайх дүүрэг)

4.2.5.тавдугаар хэсэгт (Говьсүмбэр, Говь-Алтай Багахангай, Багануур дүүрэг)

4.2.6.зургаадугаар хэсэгт (ОБЕГ-ын дэргэдэх гамшгаас хамгаалах сургалтын төв 116 дугаар анги, нийслэлийн Онцгой байдлын газар)

4.3.Гамшгаас хамгаалах ангиллын сургалт зохион байгуулах давтамжийн тоог дараах байдлаар тооцно.

4.3.1.нэгдүгээр хэсэг-гамшгаас хамгаалах ангиллын сургалт, дадлагыг улиралд 80 удаа;

4.3.2.хоёрдугаар хэсэг-гамшгаас хамгаалах ангиллын сургалт, дадлагыг улиралд 70 удаа;

4.3.3.гуравдугаар хэсэг-гамшгаас хамгаалах ангиллын сургалт, дадлагыг улиралд 60 удаа;

4.3.4.дөрөвдүгээр хэсэг-гамшгаас хамгаалах ангиллын сургалт, дадлагыг улиралд 50 удаа;

4.3.5.тавдугаар хэсэг -гамшгаас хамгаалах ангиллын сургалт, дадлагыг улиралд 45 удаа;

4.3.6.зургаадугаар хэсэг-гамшгаас хамгаалах ангиллын сургалт, дадлагыг улиралд 90 удаа;

4.4.Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг төлөвлөж зохион байгуулахдаа аймаг, нийслэлд тухайн жил, улиралд тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын төрөл, тоо, давтамж, хохирлыг (өртсөн хүн, эд хөрөнгө) үндэслэн бууруулахаар дараа жил, улиралд зохион байгуулах сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.

4.5.Нэг удаагийн сургалтыг 20-оос доошгүй хүнд зохион байгуулах ба сургалт авах хүсэлт ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн сургалтад хамрагдах хүний тоо хангалтгүй тохиолдолд бусад хүсэлт гаргасан байгууллагатай хамтатган зохион байгуулж тооцож болно.

4.6.Сургалтын чанар, үр дүнг тооцохдоо оролцогчдоос сургалтын өмнө болон дараах асуулт тестээр авах ба түвшин тогтоох шалгалтын агуулга, тестийг нэгдсэн байдлаар гаргаж, цахим сайтад олон нийтэд байршуулна. Сургалтын дараа сэтгэл ханамжийн судалгааг авч, багшийн ур чадварыг 1-5 оноогоор, аюулт үзэгдэл, ослын статистик тоо мэдээнд тулгуурлан сургалтын үр дүн, чанар, амжилтыг тус бүр 10 хүртэл оноогоор дүгнэнэ.

4.7.Сургалтыг дүгнэхдээ нотломжид үндэслэн, шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараах аргачлалын дагуу хувиар илэрхийлэн үнэлнэ.

$$\text{Жил}_{\text{АС дундаж}} = \frac{I_{\text{АС}} + II_{\text{АС}} + III_{\text{АС}} + IV_{\text{АС}}}{4}$$

Жишээ:

$$\text{Жил}_{\text{АС дундаж}} = \frac{I_{\text{АС}} + II_{\text{АС}} + III_{\text{АС}} + IV_{\text{АС}}}{4} = \frac{82\% + 89,24\% + 81,1\% + 96,6\%}{4} = 87.36\%$$

АС – ангиллын сургалт¹

$$\text{Хэрэгжилт}_{\text{АС}} = \frac{\text{Хүрсэн түвшин}}{\text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

4.8.Гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг зохион байгуулсан байдлыг үнэлэх.

4.8.1.Тухайн улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн сургалтыг, гүйцэтгэлд нь харьцуулан дүгнэнэ. Жишээ нь: улиралд 50 удаа зохион байгуулсан байхаас 40 удаа зохион байгуулсан бол 80 хувь “В” буюу Сайн үнэлгээтэй гэж дүгнэнэ.

$$\text{Хэрэгжилт}_{\text{АС}} = \frac{40 \cdot 100\%}{50} = 80 \%$$

АС – ангиллын сургалт

Жишээ: Булган аймаг

$$\text{Хэрэгжилт}_{\text{IAC}^2} = \frac{40 \cdot 100\%}{50} = 80 \% = 28 \text{ оноо}$$

$$\text{Хэрэгжилт}_{\text{IIAC}^3} = \frac{45 \cdot 100\%}{50} = 90 \% = 31.5 \text{ оноо}$$

$$\text{Хэрэгжилт}_{\text{IIICAC}^4} = \frac{40 \cdot 100\%}{50} = 80 \% = 28 \text{ оноо}$$

$$\text{Хэрэгжилт}_{\text{IVAC}^5} = \frac{50 \cdot 100\%}{50} = 100 \% = 35 \text{ оноо}$$

Гамшгаас хамгаалах ангиллын сургалт зохион байгуулсан байдлыг дараах байдлаар үнэлнэ (хүснэгт 3.1). Жишээ нь: Зэрэглэлээс хамаарч улиралд 50 удаа зохион байгуулах сургалтыг 100 хувийн гүйцэтгэлтэй зохион байгуулсан бол 35 оноо, харин 40 удаа буюу 80 хувийн гүйцэтгэлтэй зохион байгуулсан бол 28 оноо өгнө.

$$\text{Хэрэгжилт}_{\text{АС}} = \frac{80\% \cdot 35}{100} = 28$$

4.8.2.Тухайн улиралд зохион байгуулсан сургалтын мэдээллийг цахим бүртгэлд оруулахдаа гүйцэтгэлд нь харьцуулан дүгнэнэ. Жишээ нь: 50 удаагийн сургалтын мэдээллийг цахим бүртгэлд оруулсан байхаас 40 удаагийн мэдээллийг оруулсан бол 80 хувь “В” буюу Сайн үнэлгээтэй гэж дүгнэнэ.

$$\text{Хэрэгжилт}_{\text{ЦБ}} = \frac{40 \cdot 100\%}{50} = 80 \%$$

ЦБ⁶ – цахим бүртгэл

Жишээ:

¹ АС-ангиллын сургалт

² IAC- I улирлын ангиллын сургалт

³ IIAC- II улирлын ангиллын сургалт

⁴ IIICAC- III улирлын ангиллын сургалт

⁵ IVAC- IV улирлын ангиллын сургалт

⁶ ЦБ-Цахим бүртгэл

$$\begin{aligned} \text{Хэрэгжилт}_{I\text{цб}} &= \frac{32 * 100\%}{40} = 80 \% = 8 \text{ оноо} \\ \text{Хэрэгжилт}_{II\text{цб}} &= \frac{41 * 100\%}{45} = 90 \% = 9 \text{ оноо} \\ \text{Хэрэгжилт}_{III\text{цб}} &= \frac{31 * 100\%}{40} = 76 \% = 7.6 \text{ оноо} \\ \text{Хэрэгжилт}_{IV\text{цб}} &= \frac{48 * 100\%}{50} = 96 \% = 9.6 \text{ оноо} \end{aligned}$$

4.8.3. Зохион байгуулсан гамшгаас хамгаалах ангиллын сургалтын мэдээллийг цахим бүртгэлд оруулсан байдлыг дараах байдлаар үнэлнэ (хүснэгт 3.2) Жишээ нь: 50 удаа зохион байгуулсан сургалтын мэдээллийг 100 хувийн гүйцэтгэлтэй оруулсан бол 10 оноо, харин 80 хувийн гүйцэтгэлтэй оруулсан бол 8 оноо өгнө.

$$\text{Хэрэгжилт}_{\text{цб}} = \frac{80\% * 35}{100} = 8$$

4.8.4. Сургалтын амжилтыг тухайн улиралд сургалтад хамрагдсан нийт хүний тоо ($N_{\text{н.х.х.}}$ ⁷)-г сургалтад хамрагдвал зохих хүний тоо ($N_{\text{н.з.х.}}$ ⁸)-д харьцуулж 100%-д үржүүлж гаргана, улирал бүрийн сургалтын амжилтыг нэмж 4-д хуваан жилийн дунджийг гаргана (хүснэгт 3.3).

$$\text{Амжилт}_I = \frac{N_{\text{н.х.х.}}}{N_{\text{н.з.х.}}} * 100\%$$

Жишээ:

$$\begin{aligned} \text{Амжилт}_I &= \frac{N_{\text{н.х.х.}}}{N_{\text{н.з.х.}}} * 100\% = \frac{1050}{1207} * 100\% = 86.9\% = 8.7 \text{ оноо} \\ \text{Амжилт}_{II} &= \frac{N_{\text{н.х.х.}}}{N_{\text{н.з.х.}}} * 100\% = \frac{1116}{1207} * 100\% = 92.4\% = 9.24 \text{ оноо} \\ \text{Амжилт}_{III} &= \frac{N_{\text{н.х.х.}}}{N_{\text{н.з.х.}}} * 100\% = \frac{936}{1207} * 100\% = 79.8\% = 8 \text{ оноо} \\ \text{Амжилт}_{IV} &= \frac{N_{\text{н.х.х.}}}{N_{\text{н.з.х.}}} * 100\% = \frac{1150}{1207} * 100\% = 95.2\% = 9.5 \text{ оноо} \end{aligned}$$

4.8.5. Сургалтын чанарыг сургалтын дараах тестээр 60-100 оноо авсан нийт хүний тоог ($N_{60\%}$) сургалтад хамрагдсан хүний тоо ($N_{\text{н.х.х.}}$)-нд харьцуулж 100%-д үржүүлж гаргана. Нэг сургалтад хамрагдсан 30 хүнээс 18 хүн 60-аас дээш оноогоор үнэлэгдсэн бол сургалтын чанар 60%-тай байна, улиралд нийт орсон сургалтын чанарыг нэмж, орсон сургалтын тоонд хуваан дунджийг гаргана. Сургалтын чанарыг 6-10 хүртэл оноогоор үнэлэнэ (хүснэгт 3.4).

$$\text{Чанар} = \frac{N_{60\%}}{N_{\text{н.х.х.}}} * 100\%$$

Жишээ:

⁷ Нн.х.х.-сургалтад нийт хамрагдсан хүний тоо

⁸ Нн.з.х.-сургалтад нийт хамрагдвал зохих хүний тоо

$$\text{Чанар} = \frac{N_{60\%}}{N_{\text{н.х.х.}}} * 100\% = \frac{18}{30} * 100\% = 60\% = 6 \text{ оноо}$$

Жич: Сургалтын чанар 60-аас дээш хувьтай байна. Хэрвээ сургалтын чанар муу байвал тухайн сургалт үр дүнгүй болсонд тооцож, сургалтыг тухайн байгууллага, иргэдэд дахин орно.

4.8.6. Тухайн улиралд зохион байгуулсан сургалтын материал бүрдүүлж, зурагжуулж, хавтасласан байдлын гүйцэтгэлд нь харьцуулан дүгнэнэ (хүснэгт 3.5). Жишээ нь: 50 удаагийн сургалтын материал бүрдүүлсэн байхаас 40 удаагийн материал бүрдүүлсэн бол 80 хувь "В" буюу Сайн үнэлгээтэй гэж дүгнэнэ.

$$\text{Хэрэгжилт}_{\text{МБ}^9} = \frac{40 * 100\%}{50} = 80\%$$

$$\text{Хэрэгжилт}_{\text{IМБ}^{10}} = \frac{45 * 100\%}{50} = 90\% = 9 \text{ оноо}$$

$$\text{Хэрэгжилт}_{\text{IIМБ}^{11}} = \frac{40 * 100\%}{50} = 80\% = 8 \text{ оноо}$$

$$\text{Хэрэгжилт}_{\text{IIIМБ}^{12}} = \frac{45 * 100\%}{50} = 90\% = 9 \text{ оноо}$$

$$\text{Хэрэгжилт}_{\text{IVМБ}^{13}} = \frac{48 * 100\%}{50} = 96\% = 9.6 \text{ оноо}$$

Материал бүрдүүлсэн байдлыг дараах байдлаар үнэлнэ (хүснэгт 1.3). Жишээ нь: 50 удаа зохион байгуулсан сургалтын материалыг 100 хувийн гүйцэтгэлтэй бүрдүүлсэн бол 10 оноо, харин 80 хувийн гүйцэтгэлтэй бүрдүүлсэн бол 8 оноо өгнө.

$$\text{Хэрэгжилт}_{\text{МБ}} = \frac{80\% * 10}{100} = 8$$

4.9. Үр дүнд суурилсан чанарын шалгуур үзүүлэлтийн дүгнэлтийг гамшиг ослын тохиолдлын тоог 100 мянган хүн амд, өмнөх оны мөн үетэй харьцуулж өсөлт бууралтыг хувьчилж тооцно. Гамшиг ослын тохиолдол 10 дээш хувьтай бол 25 оноо, 5-10 хувьтай бол 15 оноо, 0-5 хувьтай бол 5 оноо, тохиолдол ихэссэн бол 0 оноогоор дүгнэнэ (хүснэгт 3.6).

Жишээ: Булган аймаг 2024 онд 61161 хүн амтай, объектын гал түймрийн тоо 92 байсан, энэ нь 100 мянган хүн амд 150 гэсэн үг. 2025 онд 60535 хүн амд 85 объектын гал түймрийн тохиолдол байсан нь 100 мянган хүн амд 141 болж буурсан. Улмаар объектын гал түймрийн чанар 6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

⁹ МБ-материал бүрдүүлэлт

¹⁰ IМБ-I улирлын материал бүрдүүлэлт

¹¹ IIМБ-II улирлын материал бүрдүүлэлт

¹² IIIМБ-III улирлын материал бүрдүүлэлт

¹³ IVМБ-IV улирлын материал бүрдүүлэлт

$$\Gamma_{100\text{мян.}}^{2024} = \frac{100\,000 * \Gamma_{15}^{2024}}{N_{\text{хүн ам}}^{2024}} = \frac{100\,000 * 92}{61161} = 150$$

$$\Gamma_{100\text{мян.}}^{2025} = \frac{100\,000 * \Gamma^{2025}}{N_{\text{хүн ам}}^{2025}} = \frac{100\,000 * 85}{60535} = 141$$

$$\Psi_{\text{Гал}}^{2025} = \frac{\Gamma_{100\text{мян.}}^{2025}}{\Gamma_{100\text{мян.}}^{2024}} * 100 - 100 = \left(\frac{141}{150} * 100\right) - 100 = 94 - 100 = -6 \text{ (15 оноо)}$$

4.10. Гамшгаас хамгаалах ангиллын сургалт зохион байгуулсан талаар тоон болон үсгэн үнэлгээгээр дараах байдлаар дүгнэнэ.

- 90-100 оноо А буюу “Маш сайн”,
- 80-89 оноо В буюу “Сайн”,
- 70-79 оноо С буюу “Хангалттай”,
- 60-69 оноо D буюу “Дутагдалтай”,
- 50-59 оноо F буюу “Хангалтгүй”.

4.11. ОБЕГ-ын харьяа гамшгаас хамгаалах сургалтын төв 116 дугаар анги, нийслэл, орон нутгийн Онцгой байдлын газрын зохион байгуулсан сургалтын тайлан, мэдээг Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас хамгаалах сургалтын газарт ирүүлнэ. Үүнд:

-Сургалтын чанар үр дүнг гамшгийн тохиолдлын өсөлт, бууралттай харьцуулан дүгнэж, цаашид авах арга хэмжээний талаар зохион байгуулсан хэлэлцүүлгийн тэмдэглэл;

-Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын мэдээ (маягт-СМ-1);

-Гамшгаас хамгаалах ангиллын сургалт зохион байгуулсан байдалд өгөх үнэлгээний хуудас (хавсралт-3);

-Гамшгаас хамгаалах ангиллын сургалт зохион байгуулсан тухай баталгааны хуудас (хавсралт-4).

ТАВ. НЭГТГЭЖ ДҮГНЭХ

5.1. Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх Гамшгаас хамгаалах сургалтын төв 116 дугаар анги, аймгийн Онцгой байдлын газрын сургалт, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах ажлыг (сар, улирал, хагас, бүтэн жил) штабын дарга, газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга, нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга дүгнэж, ангийн захирагч болон Онцгой байдлын газрын дарга нар дүнг баталгаажуулна.

5.2. Ажил дүгнэсэн дүн, тайлан, баталгааны хуудас, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, сургалтын ажлын тоон мэдээг улирлаар сүүлийн сарын 20-ны дотор, хагас жилээр 06 дугаар сарын 10-ны дотор, бүтэн жилээр 12

¹⁴ $\Gamma_{100\text{мян.}}^{2024}$ -100 мянган хүн тутамд тохиолдсон гал түмрийн дуудлагын тоо

¹⁵ Γ^{2024} -2024 оны нийт галын дуудлага

¹⁶ $N_{\text{хүн ам}}^{2024}$ -2024 оны нийт хүн ам

¹⁷ $\Psi_{\text{Гал}}^{2025}$ -2025 оны объектын гал түймрийн чанар

дугаар сарын 01-ний өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газар, Гамшгаас хамгаалах сургалтын газарт тус тус ирүүлнэ.

5.3.Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр хийсэн ажлыг Онцгой байдлын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газар, гамшгаас хамгаалах ангиллын сургалтыг Гамшгаас хамгаалах сургалтын газар хагас, бүтэн жилээр нэгтгэж дүгнэнэ.

5.4.Ажлын гүйцэтгэл, үр дүнгээрээ тэргүүлэн "А" буюу "Маш сайн" дүгнүүлсэн анги, газар, хэлтсийн алба хаагчдад холбогдох хууль тогтоомжийн дагуу сайшаал хүртээх, шагнах үндэслэл болно.

5.5.Ажлын гүйцэтгэл, үр дүнгээрээ "F" буюу "Хангалтгүй" дүгнүүлсэн алба хаагчдыг холбогдох хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

ЗУРГАА. БУСАД

6.1.Энэхүү зааврын хэрэгжилтэд Гамшгаас хамгаалах сургалтын төв 116 дугаар ангийн захирагч, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой байдлын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газар, Гамшгаас хамгаалах сургалтын газар хяналт тавина.

6.2.Гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр хийсэн ажилд Онцгой байдлын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газар, гамшгаас хамгаалах ангиллын сургалтад Гамшгаас хамгаалах сургалтын газар хагас, бүтэн жилээр дүн шинжилгээ хийж, тайланг Онцгой байдлын ерөнхий газрын даргад танилцуулна.

---oOo---



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн
А... тушаалын 03 дугаар хавсралт
14/12

..... АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АЖЛЫН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ

(Хүснэгт 1)

Д/д	Улирал	Улирлын ажлын дундаж үзүүлэлт										Нийт оноо	Үнэлгээ	
		Аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ (удаа)	Урьдчилан сэргийлэх ажлын талаар телевизэд өгсөн ярилцлага (удаа)	Урьдчилан сэргийлэх чиглэлээр шторк, сэрэмжлүүлгийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр явуулах (удаа)	Иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгаа зохион байгуулах (удаа)		Байгууллагын цахим сайт болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мэдээлэл байршуулах (удаа)							
					1.2		1.3		1.4		1.5			
					Хийвэл зохих	Хувь	Хийвэл зохих	Хувь	Хийвэл зохих	Хувь	Хийвэл зохих			Хувь
1	1 дүгээр улирал	3	100	6	100	80	100	36	100	180	100	100	A-F	
2	2 дугаар улирал													
3	3 дугаар улирал													
4	4 дугаар улирал													
Жилийн дундаж үнэлгээ														



Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн
А/... тушаалын 03 дугаар хавсралт
/Hh

..... АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ХИЙСЭН АЖИЛД ӨГӨХ ҮНЭЛГЭЭ

д/д	Онцгой байдлын газар	Улирлын ажлын дундаж үзүүлэлт										(Хүснэгт 2)	
		Ажлын дундаж үзүүлэлтийн биелэлт		Улирлын төлөвлөгөөний биелэлт		Төлөвлөгөөний дүн		Хийсэн ажлаа материалжуулсан байдал		Тайлан мэдээ ирүүлсэн хугацаа		Нийт оноо	Үнэлгээ
		2.1		2.2		2.3		2.4		2.5		Хувь	Хувь
		Хийвэл зохиx	Хувь	Хийвэл зохиx	Хувь	Хийвэл зохиx	Хувь	Хийвэл зохиx	Хувь	Хийвэл зохиx	Хувь		
1													
2													
3													
4													
5													
6													
7													
8													

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
 2025 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн
 А/... тушаалын 04 дүгээр хавсралт
 144

.....АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ГАМШГААС ХАМГААЛАХ АНГИЛЛЫН СУРГАЛТ
 ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙДАЛД ӨГӨХ ҮНЭЛГЭЭ (Жишээ)


Д/Д		Ажлын дундаж үзүүлэлт												(Хүснэгт 3)				
		ГХА-ын сургалт зохион байгуулсан байдал (Зохион байгуулбал зохих сургалтыг хангалттай зохион байгуулсан тохиолдолд 35 оноо)		Цахим бүртгэлд оруулсан байдал		Сургалтын амжилт		Сургалтын чанар		Хийсэн ажлаа материалжуулсан байдал		Үр дүнд суурилсан чанарын шалгуур үзүүлэлт (гамшиг ослын тоон үзүүлэлт)	Нийт оноо	Үнэлгээ				
		100%	3.1	100%	3.2	100%	10 оноо	100%	3.3	100%	10 оноо	100%	3.4	100%	10 оноо	25 оноо	100 оноо	A-F
1	1 дүгээр улирал	80	28	80	8	86,9	8,7	88	8,8	90	9	15	82	B				
2	2 дугаар улирал	90	31,5	90	9	92,4	9,2	90,6	9,06	80	8	15	89,24	B				
3	3 дугаар улирал	80	28	76	7,6	78,8	7,88	95,6	9,56	90	9	15	81,1	B				
4	4 дугаар улирал	100	35	96	9,6	95,2	9,5	89,2	8,92	96	9,6	15	96,6	A				

(Хүснэгт 3)

Жилийн дундаж үнэлгээ	87,5	30,6	85,5	34,2	88,3	8,83	90,85	9,08	89	8,9	15	87,36	B
--------------------------	------	------	------	------	------	------	-------	------	----	-----	----	-------	---

Нийлбэр дүн:
90-100 оноо "А" буюу "Маш сайн"
80-89 оноо "В" буюу "Сайн"
70-79 оноо "С" буюу "Хангалттай"
60-69 оноо "D" буюу "Дутагдалтай"
0-59 оноо "F" буюу "Хангалтгүй"

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 10 дугаар сарын 14-ны өдрийн
1412 дугаар тушаалын 05 дугаар хавсралт



АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР
ГАМШГААС ХАМГААЛАХ АНГИЛЛЫН СУРГАЛТ ЗОХИОН
БАЙГУУЛСАН ТУХАЙ БАТАЛГААНЫ ХУУДАС

СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЛБАН ТУШААЛТНЫ ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ		
Сургалтын ангилал	Сэдэв	Сургалт зохион байгуулсан алба хаагч
☐ Гамшгаас хамгаалах иж бүрэн ☐ Гамшгаас хамгаалах команд штаб ☐ Удирдах бүрэлдэхүүн ☐ Алба, Мэргэжлийн анги ☐ Ажилтан, алба хаагч ☐ Иргэн ☐ Оюутан ☐ Сурагч ☐ СӨБ ☐ Цэргийн дүйцүүлэх алба ☐ Сайн дурын бүлэг, хэсэг ☐ Хөгжлийн бэрхшээлтэй иргэн Тайлбар: Энэ хэсгээс хэд хэдийг сонгож болох бөгөөд сонголт тус бүрийн ард сургалтад хамрагдсан хүний тоог тавьна.		
Сургалтын төрөл: ☐ Танхим ☐ Дадлага ☐ Хосолсон ☐ Цахим ☐ Видео ☐ Дууриалган үзүүлэх	Сургалт зохион байгуулсан огноо: 202... он сар өдөр	Сургалт зохион байгуулсан хугацаа: цаг минут
Хамрагдсан хүний тоо: Эр: Эм: Нийт:		
Сургалтын амжилт:% Сургалтын чанар:%		
СУРГАЛТАД ХАМРАГДСАН ХУУЛИЙН ЭТГЭЭД, ИРГЭНИЙ ӨГӨХ МЭДЭЭЛЭЛ		
Байгууллагын нэр:	Хаяг:	Үйл ажиллагааны чиглэл:
Сургалтын талаарх санал, дүгнэлт:	Үнэлгээ: ☐ Бүрэн хангалттай ☐ Хангалттай ☐ Хангалтгүй Тайлбар:	

Сургалт авсан байгууллагын эрх бүхий алба тушаалтан:

АЛБАН ТУШААЛ / /
Тэмдэг, гарын үсэг, гарын үсгийн тайлал
Утасны дугаар: